БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Э.БАТТУЛГА

2022 оны ... дүгээр сарын ...өдөр

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТҮЛХҮҮР ЗҮЙЛҮҮДИЙН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭХ СУДАЛГАА ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны .... дүгээр сарын ....өдөр № ... Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	**Ажлын үндэслэл:**	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн Босголтын Зээлийн банкнаас БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн 2, 3-р үе шатны үйл ажиллагаа 2020 оны 3-р сараас эхэлсэн. 2020–2027 онд 7 жилийн хугацаанд хэрэгжих энэхүү төслийн нийт санхүүжилт 32.25 сая евро бөгөөд Германы Засгийн газраас 27.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн дэмжлэг үзүүлэх ба Монголын Засгийн газраас 4.75 сая еврогийн хөрөнгө оруулалт хийгдэх юм. Төслийн Зорилго: Монгол орны БОАЖЯ-ны ТХГН-ийн сүлжээнд (Орчны бүс нутаг, эко холбоос нутгууд болон Орон нутгийн захиргаад, иргэд) чухал ач холбогдол бүхий газруудын үр ашигт байдал, тогтвортой менежментийг сайжруулах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх юм. Төсөл нь 4 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэйгээр хэрэгжинэ. Үүнд: Бүрэлдэхүүн хэсэг 1: ТХГН-ийн болон Кластерийн (орчны бүс, эко-коридоруудыг хамруулан) менежментийн ба бизнесийн төлөвлөлтийг Олон улсын байгаль хамгаалах холбоо (ОУБХХ-IUCN)-ны удирдамж, стандартын дагуу шинэчлэн сайжруулах, ТХГН-ийн сүлжээний хэмжээнд менежментэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах; Бүрэлдэхүүн хэсэг 2: Газарзүйн томоохон бүс нутаг буюу төсөлд хамрагдсан таван Кластерын менежментийн болон бизнесийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 3: Тогтоосон шалгуурын дагуу сонгосон бие даасан 7 ТХГН-ийн менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 4: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулах; зэрэг болно. Төслийн үр дүнг үнэлэх үндсэн шалгууруудыг тодорхойлох зорилгоор биологийн олон янз байдал, түлхүүр зүйлүүдийн талаарх суурь мэдээлэл бүрдүүлэх шаардлагатай байна.

2	**Ажлын зорилго:**	Төслийн кластер бүс нутаг дахь УТХГ болон ОНТХГ-дад биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн тархалт, нөөц, сүргийн бүтэц, нүүдэл шилжилт хөдөлгөөн (эко коридор) нутгуудыг тодорхойлох суурь мэдээллийг бүрдүүлэхэд зөвлөх үйлчилгээний зорилго оршино.
3	**Хамрах хүрээ:**	Кластер нутгуудад тархсан түлхүүр зүйлүүд нь ОУБХХ (IUCN) болон Монгол Улсын улаан номд бүртгэгдсэн хамгааллын статус өндөртэй буюу CR-Нэн ховор, EN-ховор, VU-Эмзэг зүйлүүд төдийгүй тухайн кластер нутаг, ТХГН-ын менежментийн төлөвлөгөөнд түлхүүр зүйлээр тодорхойлогдсон байна. Энэхүү шалгуурт багтсан түлхүүр зүйлүүдийн суурь судалгаагаар төслийн хэрэгжилтийн дүнд Биологийн олон янз байдлын гол түлхүүр зүйлүүдийн төлөв байдлыг тогтоон тэдгээрийн амьдрах орчныг холбосон экологийн холбоос (коридор) нутгуудад хамгааллын ямар менежментийг арга хэмжээг хэрэгжүүлэх, гарч болох эрэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, өөрчлөлтийг үнэлэхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлнэ. Төсөл хэрэгжиж буй 5 кластерт хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүс, экологийн коридор бүхий сумдаас тодорхой шалгуурын дагуу сонгон авна. Хавсралт 1. Кластеруудад хамрагдсан аймаг, сумдын болон УТХГ-ын жагсаалт. Хавсралт 2. Кластер болон ТХГН-ийн түлхүүр зүйлүүдийг хамгааллын статус.
4	**Ажил гүйцэтгэх хугацаа:**	Гэрээнд гарын үсэг зурснаас хойш **6** сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.
5	**Ажлын иж бүрдэл, хийх ажил:**	• Гүйцэтгэгч нь төсөл хэрэгжиж байгаа кластерт хамрагдсан ТХГН-ийн хамгаалалтын захиргаадтай холбогдож, тухайн кластерт орж буй газар нутгийн талаарх мэдээллийг авч судалгаа хийх газар нутгийг тодорхойлох, • Төслийн кластерт хамрагдаж буй газар нутаг, сум, багийн биологийн олон янз байдлын түлхүүр зүйлийн талаарх ерөнхий мэдээллийг БОАЖЯ-ны ТХБНУГ болон бусад эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, Биосан, Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн сангаас болон бусад холбогдох материалаас түүвэрлэх, • Тухайн кластерт хамрагдаж буй тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд үндэслэн хээрийн судалгааг хийж гүйцэтгэнэ. • Судалгаанд сонгон авсан газар нутаг болон кластер нутагт өмнө нь судалгаа, шинжилгээний байгууллага, Олон улсын болон гадаадын байгууллага, ТББ, төсөл, хөтөлбөрүүдээр хийгдсэн адил төсөөтэй судалгааны тайлан, мэдээ материалд дүн шинжилгээ хийх, • Тухайн ТХГ-ын орчны бүсийн сумдаас сонгон авч, биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн нарийвчилсан хээрийн судалгааг газар дээр нь очиж гүйцэтгэх, • Биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн судалгааг төслийн ерөнхий зорилго, зорилтуудтай нийцүүлэн Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэнэ.

		• Түлхүүр зүйлүүдэд занал хийж буй нөхцөл байдлыг тодорхойлох. Үүнд: хулгайн ан, өвчлөл, бэлчээрийн давхцал, идэш тэжээлийн хэлхээ, цаг уурын өөрчлөлт гэх мэт. • Кластер нутгуудын биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн амьдрах орчны загвар болон коридор нутгуудыг нарийвчилсан тогтоож, уг мэдээллийг GIS мэдээллийн санд оруулж нарийвчилсан тархалт, нүүдэл шилжилт хөдөлгөөний зураг боловсруулна. • Гэрээлэгч нь БОАЖЯ, БОЯБХУАӨДЗТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг, Төслийн Зөвлөх багийн Ховд аймаг дахь салбар, Кластерийн менежментийн зөвлөл, Аймгуудын БОАЖГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, сумын холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.
6	**Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага:**	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь **8-аас** доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. **Зөвлөхийн багийн бүрэлдэхүүн, ажлын туршлага:** **Багийн ахлагч / Биологийн ухааны Доктор (1 хүн):** • Монгол орны биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; • ТХГН-ын ховор амьтад, тэдгээрийн амьдрах орчны судалгаа хамгааллын чиглэлээр ажиллаж байсан; • Хээрийн судалгаа хийх, судалгааны арга зүй боловсруулах, эко коридорыг тодорхойлох талаар туршлагатай ийм төрлийн ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай байна. • Ижил төстэй Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн Биологийн олон янз байдлын судалгаанд оролцож байсан буюу хэрэгжүүлж байсан туршлагатай; • Биологийн олон янз байдалд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, түүнд дасан зохицох, буруулах чиглэлийн талаарх мэдлэгтэй бол давуу тал болно; • Англи хэлний бичгийн өндөр мэдлэгтэй байх **Багийн гишүүн / Амьтан судлаач (4 хүн):** • Биологи эсвэл экологийн чиглэлээр магистр эсвэл түүнээс дээш зэрэгтэй; • Зэрлэг амьтдын мониторинг судалгаа, хамгааллын биологийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх; • Зүйлийн тархцын загвар, амьдрах орчны загварчлал талаарх мэдлэгтэй, гарсан үр дүнг тайлбарлаж чаддаг байх; • Биологийн олон янз байдлын талаарх мэдээллийн сан (тухайлбал БИОСАН) болон байгаль орчны мэдээллийн сан эх сурвалж (жишээ нь: www.eic.mn)-ийн талаарх мэдлэгтэй, тэдгээрийг ашиглах чадвартай; • ТХГН-ын ховор амьтад, тэдгээрийн амьдрах орчны судалгаа хамгааллын талаарх мэдлэгтэй. **Багийн гишүүн /Газарзүйн Мэдээллийн Систем (GIS)-ийн мэргэжилтэн (2 хүн):** • GIS эсвэл зайнаас тандан судлалын чиглэлээр бакалавр эсвэл түүнээс дээш зэрэгтэй; • GIS болон зайнаас тандан судлалын арга зүйг ашиглаж зэрлэг амьтдын тархцын загвар, амьдрах орчны холбоос

		нутгийг тодорхойлох, эсвэл эдгээртэй ижил төстэй орон зайн өгөгдөл дээр ажиллаж байсан туршлагатай; • Уур амьсгалын өгөгдөл, тухайлбал BIOCLIM, GCM (Global Climate Models) зэрэг мэдээллийн сангийн талаарх мэдлэгтэй, эдгээрийг ашиглах чаддаг байх; **Багийн гишүүн / Ургамал судлаач (1 хүн):** • Зэрлэг амьтны идэш тэжээл, бэлчээрийн менежментээр мэргэшсэн байх Магистр эсвэл түүнээс дээш зэрэгтэй; • Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өндөр уулын ургамалжилтыг тодорхойлох, хээрийн судалгаа хийж байсан бодит туршлагатай байх • Бэлчээрийн төлөв байдалд хянан магадалгаа хийж, ургац, арви, бүрхэц тодорхойлж байсан туршлагатай; • Зэрлэг амьтны идэш тодорхойлох, идэш тэжээл, ургамлын нөөцийн талаар судалгаа хийж байсан туршлагатай; • Мэдээ материалыг нэгтгэн дүгнэх, тайлан бичих өндөр чадвартай; • Бэлчээрийн зураглал хийх чадвартай байх; • Багаар ажиллах чадвартай, харилцааны өндөр соёлтой; • Англи хэлний мэдлэгтэй байх; **Багийн бусад гишүүн (туслах ажилтнууд, жолооч, тогооч зэрэг):** • Багийн гишүүдэд тавигдах нийтлэг шаардлагууд: /Багийн гишүүнд • ТХГН-ийн биологийн олон янз байдлын судалгаа, мониторингд оролцож байсан туршлагатай; • Мэдээ материалыг нэгтгэн дүгнэх, хэвлэн нийтлэх өндөр чадвартай; • Багаар ажиллах чадвартай, харилцааны өндөр соёлтой; • Биологийн олон янз байдлын тоо хэмжээг тогтооход олон улсын түвшинд хэрэглэдэг арга зүйнүүдийг мэддэг, хэрэглэж чаддаг; • Англи хэлний мэдлэг сайтай байх. • Сансрын дохиололтой хүзүүвчний мэдээлэлд үндэслэсэн ан амьтдын мониторинг судалгаа хийх Монгол улсын оюуны өмчийн эрхийн гэрчилгээ авсан бол давуу тал болно.
7	**Захиалагч байгууллага:**	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл
8	**Хүрэх үр дүн:**	1. Төслийн явцын болон нөлөөллийн мониторинг хийхэд зориулж Биологийн олон янз байдлын түлхүүр зүйлийн суурь мэдээллийг бүрдүүлсэн байна. 2. Биологийн төрөл зүйл (Түлхүүр зүйлүүдэд) тулгамдаж буй аюул занал болон бусад сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон зөвлөмж боловсруулагдсан байна. 3. Биологийн олон янз байдлын ашиглалт, агнуурын менежментийн хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болно.
9	**Хүлээн авах материал:**	• Биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн суурь судалгааны дэлгэрэнгүй болон хураангуй тайланг англи, монгол хэл дээр ирүүлнэ,

		• Түлхүүр зүйлүүдийн 1:500.000 масштаб бүхий тархалтын зургийг газар зүйн мэдээллийн систем дээр суурилан боловсруулж, орон зайн мэдээллийг (.shp) өгнө. • Кластер нутгийн хэмжээнд түлхүүр зүйлүүдийн тархалт, нөөц болон эко-холбоос нутгуудыг тодорхойлох, хамгааллын менежментийн зөвлөмж, • Экологийн холбоос нутгуудыг тодорхойлж, нарийвчилсан газрын зургийг GIS дээр боловсруулж суурь зураг хийх, орон зайн мэдээллийг (.shp) өгнө. • Зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын хугацаанд хийсэн холбогдох бүх мэдээ, баримт, тайлан, фото зураг, видео, мэдээллийн сан, тархалтын зураг, газрын зургийг хэвлэмэл болон файл хэлбэрээр 3% захиалагч талд хүлээлгэж өгнө.
10	**Санхүүжилтийн эх үүсвэр:**	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”
11	**Санхүүжилтийн дүн**	280,000,000.00 (хоёр зуун наян сая) төгрөг
12	**Худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт**	– KfW банкны 2019 батлагдсан “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”-ын 2.1.3 дахь заалт (Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журам) – KfW банкны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн бодлогын шаардлага – Иргэний хууль

ТАНИЛЦСАН:

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БҮС НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Д.БАТМӨНХ, 2022 оны 4 сарын 26

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — 2022 оны ... сарын ....

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ — Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН, 2022 оны ... сарын ...

ХЯНАСАН:

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

АМЬТАН, УРГАМАЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Цахимаар танилцсан. Э.САНСАРБАЯР, 2022 оны 4. сарын 14

БОЛОВСРУУЛСАН:

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД:

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ БҮС НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН — Т.БОЛДБААТАР, 2022 оны 04 сарын 14

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

О.БАТСАЙХАН
2022 оны 4 сарын 14

БУЛАГ ШАНД, ГОЛ МӨРНИЙ ЭХИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТЭРГҮҮН

А.ОЮУНЧИМЭГ
2022 оны 04 сарын 08

СЭТГЭЛ ЗҮЙ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН

М.ОРГИЛ
2022 оны 4 сарын 08

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН МЕНЕЖМЕНТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ

О.МЭНДБААТАР
2022 оны 04 сарын 08

<u>ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:</u>

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ц.АМАРБАЯР
2022 оны 04 сарын 08

ХАВСРАЛТ 1. КЛАСТЕРУУДАД ХАМРАГДСАН АЙМАГ, СУМД БОЛОН УТХГ-ЫН НЭРС

Кластер-1	Кластер-2	Кластер-3	Кластер-4	Кластер-5
Увс аймаг: 1. Сагил, 2. Түргэн, 3. Тариалан, 4. Ховд, 5. Бөхмөрөн, Баян-Өлгий аймаг 2 сум: 6. Улаанхус 7. Ногооннуур	**Ховд аймаг**: 1. Ховд 2. Дуут 3. Цэцэг 4. Мөнххайрхан 5. Мөст 6. Булган 7. Алтай 8. Үенч Баян-Өлгий аймаг 2 сум: 9. Дэлүүн, 10. Булган	**Увс аймаг:** 1. Давст 2. Наранбулаг 3. Завхан 4. Цагаанхайрхан 5. Улаангом 6. Өндөрхангай 7. Малчин 8. Хяргас 9. Зүүнговь 10. Тэс 11. Баруунтуруун 12. Тариалан 13. Түргэн 14. Зүүнхангай	**Ховд аймаг:** 1. Манхан 2. Зэрэг 3. Дарви 4. Чандмана 5. Дөргөн 6. Мянгад 7. Буянт 8. Жаргалант 9. Эрдэнэбүрэн 10. Ховд Завхан аймаг 1 сум: 11. Дөрвөлжин, Увс аймаг 2 сум: 12. Өмнөговь 13. Өлгий Баян-Өлгий аймаг 2 сум: 14. Алтанцөгц 15. Баяннуур	**Ховд аймаг:** 1. Булган 2. Алтай 3. Үенч Говь-Алтай аймаг 5 сум: 4. Тонхил 5. Бугат 6. Алтай 7. Цогт 8. Эрдэнэ Баянхонгор аймаг 2 сум: 9. Баян-Өндөр 10. Шинэжинст
Улсын ТХГ-4: 1. Түргэн уулын ДЦГ, 2. Цагаан Шувуут уулын ДЦГ, 3. Сийлхэмийн нурууны БЦГ "А" 4. Сийлхэмийн нурууны БЦГ "Б" 5. Гулзат ОНТХГ	Улсын ТХГ-5: 1. Мөнххайрханы БЦГ, 2. Мянган Угалзатын нурууны БЦГ, 3. Чигэртэйн голын ай савын БЦГ, 4. Булган Их Онгогийн БЦГ, Хөх сэрхийн нурууны ДЦГ	Улсын ТХГ-8: 1. Увс нуурын ай савын ДЦГ, 2. Ханхөхийн нурууны БЦГ, 3. Хяргас нуурын БЦГ, 4. Алтан элсний ДЦГ, 5. Тэсийн голын сав газрын БНГ, 6. Булганхангай уулын БНГ, 7. Мөнгөт цахирын БДГ, 8. Ачит нуур Дэвлийн арлын БЦГ	Улсын ТХГ-4: 1. Хар Ус нуурын БЦГ, 2. Цамбагарав уулын ДЦГ, 3. Алтан хөхийн БНГ, 4. Манханы тал БНГ, 5. Хомын талын БЦГ,	Улсын ТХГ-4: 1. Говийн Их ДЦГ-ын А, 2. Говийн Их ДЦГ-ын Б хэсэг, 3. Алаг Хайрхан уулын БНГ, 4. Эзж Хайрхан уулын БДГ

ХАВСРАЛТ 2. КЛАСТЕР БОЛОН ТХГН-ИЙН ТҮЛХҮҮР ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛЛЫН СТАТУС

- **Кластер 1, 2:** Цоохор ирвэс Snow leopard *(Pantheria uncia)* (VU, IUCN; CITES AP-I, Global status: Endangered), Аргӓль хонь, Argali mountain sheep *(Ovis ammon)* NT, CITES AP-II,
- **Кластер 3:** Халиун буга, Deer *(Cervus elaphus)*, бүс нутгийн хэмжээнд Ховор, Red list of Mongolia, Бор гөрөөс, Siberian roe deer *(Capreolus pygargus)*
- **Кластер 4:** Бөхөн, Saiga antelope *(Saiga tatarica mongolica)* CR, Global status, CITES II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* -VU,
- **Кластер 5:** Хулан адуу, Khulan *(Equus hemionus hemionus)* NT, Global status Vulnerable, CITES-II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* VU, global status

ХАВСРАЛТ 1. КЛАСТЕРУУДАД ХАМРАГДСАН АЙМАГ, СУМД БОЛОН УТХГ-ЫН НЭРС

Кластер-1	Кластер-2	Кластер-3	Кластер-4	Кластер-5
Увс аймаг: 1. Сагил, 2. Түргэн, 3. Тариалан, 4. Ховд, 5. Бөхмөрөн, Баян-Өлгий аймаг 2 сум: 6. Улаанхус 7. Ногооннуур	**Ховд аймаг**: 1. Ховд 2. Дуут 3. Цэцэг 4. Мөнххайрхан 5. Мөст 6. Булган 7. Алтай 8. Үенч Баян-Өлгий аймаг 2 сум: 9. Дэлүүн, 10. Булган	**Увс аймаг:** 1. Давст 2. Наранбулаг 3. Завхан 4. Цагаанхайрхан 5. Улаангом 6. Өндөрхангай 7. Малчин 8. Хяргас 9. Зүүнговь 10. Тэс 11. Баруунтуруун 12. Тариалан 13. Түргэн 14. Зүүнхангай	**Ховд аймаг:** 1. Манхан 2. Зэрэг 3. Дарви 4. Чандмана 5. Дөргөн 6. Мянгад 7. Буянт 8. Жаргалант 9. Эрдэнэбүрэн 10. Ховд Завхан аймаг 1 сум: 11. Дөрвөлжин, Увс аймаг 2 сум: 12. Өмнөговь 13. Өлгий Баян-Өлгий аймаг 2 сум: 14. Алтанцөгц 15. Баяннуур	**Ховд аймаг:** 1. Булган 2. Алтай 3. Үенч Говь-Алтай аймаг 5 сум: 4. Тонхил 5. Бугат 6. Алтай 7. Цогт 8. Эрдэнэ Баянхонгор аймаг 2 сум: 9. Баян-Өндөр 10. Шинэжинст
Улсын ТХГ-4: 1. Түргэн уулын ДЦГ, 2. Цагаан Шувуут уулын ДЦГ, 3. Сийлхэмийн нурууны БЦГ "А" 4. Сийлхэмийн нурууны БЦГ "Б" 5. Гулзат ОНТХГ	Улсын ТХГ-5: 1. Мөнххайрханы БЦГ, 2. Мянган Угалзатын нурууны БЦГ, 3. Чигэртэйн голын ай савын БЦГ, 4. Булган Их Онгогийн БЦГ, Хөх сэрхийн нурууны ~~БЦГ~~ ДЦГ	Улсын ТХГ-8: 1. Увс нуурын ай савын ДЦГ, 2. Ханхөхийн нурууны БЦГ, 3. Хяргас нуурын БЦГ, 4. Алтан элсний ДЦГ, 5. Тэсийн голын сав газрын БНГ, 6. Булганхангай уулын БНГ, 7. Мөнгөт цахирын БДГ, 8. Ачит нуур дэвлийн арлын БЦГ	Улсын ТХГ-4: 1. Хар Ус нуурын БЦГ, 2. Цамбагарав уулын ДЦГ, 3. Алтан хөхийн БНГ, 4. Манханы тал БНГ, 5. Хомын талын БЦГ,	Улсын ТХГ-4: 1. Говийн Их ДЦГ-ын А, 2. Говийн Их ДЦГ-ын Б хэсэг, 3. Алаг Хайрхан уулын БНГ, 4. Эзж Хайрхан уулын БДГ

ХАВСРАЛТ 2. КЛАСТЕР БОЛОН ТХГН-ИЙН ТҮЛХҮҮР ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛЛЫН СТАТУС

- **Кластер 1, 2:** Цоохор ирвэс Snow leopard *(Pantheria uncia)* (VU, IUCN; CITES AP-I, Global status: Endangered), Аргӓль хонь, Argali mountain sheep *(Ovis ammon)* NT, CITES AP-II,
- **Кластер 3:** Халиун буга, Deer *(Cervus elaphus)*, бүс нутгийн хэмжээнд Ховор, Red list of Mongolia, Бор гөрөөс, Siberian roe deer *(Capreolus pygargus)*
- **Кластер 4:** Бөхөн, Saiga antelope *(Saiga tatarica mongolica)* CR, Global status, CITES II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* -VU,
- **Кластер 5:** Хулан адуу, Khulan *(Equus hemionus hemionus)* NT, Global status Vulnerable, CITES-II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* VU, global status

ХАВСРАЛТ 3. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж / тоо ширхэг	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1	Зөвлөх үйлчилгээний судлаачдын цалин хөлс	8 хүн х 4 сар = 32 хүн/сар	2,500,000	80,000,000
2	Дотоодын татвар хураамж	8 хүн		18,000,000
3	* Хээрийн судалгааны ажлын зардал (албан томилолт, автомашин, унаа, тээвэр)	Хүн/хоног, км		106,200,000
4	ТХГН-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын унаа, албан томилолтын зардал,	10 ХЗ х 3 хүн х 20 хоног = 600 хүн/хоног	50,000	30,000,000
5	Талуудын чадавх бэхжүүлэх аргазүйн сургалт, семинарын зардал	5 удаа	4,000,000	20,000,000
6	Багаж, хэрэгсэл, дрон, хөдөлгөөн мэдрэгч автомат камерын батарей, эм урвалж худалдан авах, компьютерын программ хангамж, сансрын мэдээллийн төлбөр болон судалгааны зарим дээж хэрэглэхүүн шинжлүүлэх зардал			25,800,000
	Зардлын дүн			280,000,000

* *Хээрийн судалгааны ажлын зардлын задаргааг хавсаргав*

ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗАРДАЛ (АЛБАН ТОМИЛОЛТ, АВТОМАШИН, УНАА, ТЭЭВЭР)

№	Хээрийн судалгааны ажлууд	Албан томилолтын зардал	Унаа тээврийн зардал	Дүн
1	Кластер 1: Цоохор ирвэс Snow leopard *(Pantheria uncia)* (VU, IUCN; CITES AP-I, Global status: Endangered), Аргаль хонь, Argali mountain sheep *(Ovis ammon)* NT, CITES AP-II, Түргэн уулын ДЦГ, Цагаан Шувуут уулын ДЦГ, Сийлхэмийн нурууны БЦГ "А" "Б", Гулзат ОНТХГ,	5 хүн х 40 хоног х 200 хүн/хоног 50000 төгрөг = 10 000 000	Автомашин унаа тээврийн хөлс 7000 км х 1800 төг = 12 600 000	22 600 000
2	Кластер.2 Цоохор ирвэс Snow leopard *(Pantheria uncia)* (VU, IUCN; CITES AP-I, Global status: Endangered), Аргаль хонь, Argali mountain sheep *(Ovis ammon)* NT, CITES AP-II, Улсын ТХГ: Мөнххайрханы БЦГ, Мянган Угалзатын нурууны БЦГ, Чигэртэйн голын ай савын БЦГ, Булган Их Онгогийн БЦГ, Хөх сэрхийн нурууны БЦГ	5 хүн х 30 хоног х 150 хүн/хоног 50000 төгрөг = 7 500 000	Автомашин унаа тээврийн хөлс 6000 км х 1800 төг = 10 800 000	18 300 000

3	Кластер 3: Халиун буга, Deer *(Cervus elaphus)*, бүс нутгийн хэмжээнд Ховор, Red list of Mongolia, Бор гөрөөс, Siberian roe deer *(Capreolus pygargus)* Улсын ТХГ: Увс нуурын ай савын ДЦГ, Ханхөхийн нурууны БЦГ, Хяргас нуурын БЦГ, Алтан элсний ДЦГ, Тэсийн голын сав газрын БНГ, Булганхангай уулын БНГ, Мөнгөт цахирын БДГ, Ачит нуур дэвлийн арлын БЦГ	5 хүн х 40 хоног х 200 хүн/хоног 50000 төгрөг = 10 000 000	Автомашин унаа тээврийн хөлс 8000 км х 1800 төг = 14 400 000	24 400 000
4	Кластер 4: Бөхөн, Saiga antelope *(Saiga tatarica mongolica)* CR, Global status, CITES II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* - VU, Хар Ус нуурын БЦГ, Цамбагарав уулын ДЦГ, Алтан хөхийн БНГ, Манханы тал БНГ, Хомын талын БЦГ	5 хүн х 30 хоног х 150 хүн/хоног 50000 төгрөг = 7 500 000	Автомашин унаа тээврийн хөлс 6000 км х 1800 төг = 10 800 000	18 300 000
5	Кластер 5: Хулан адуу, Khulan *(Equus hemionus hemionus)* NT, Global status Vulnerable, CITES-II, Хар сүүлт, Black tailed gazelle *(Gazella subgutturosa)* VU, global status Говийн Их ДЦГ-ын А, Б хэсэг, Алаг Хайрхан уулын БНГ, Ээж Хайрхан уулын БДГ	5 хүн х 40 хоног х 200 хүн/хоног 50000 төгрөг = 10 000 000	Автомашин морь, хөлслөх зардал 7000 км х 1800 төг = 12 600 000	22 600 000
	Хээрийн судалгааны ажлын зардлын нийт дүн			**106 200 000**